ӨМНӨГОВЬ АЙМАГ
СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 03 сарын 19 өдөр Дугаар 07/05 Сайншанд

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дүрэм шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.2.4 дахь заалтыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:


1. Сэврэй сумын Нийтлэг үйлчилгээний газар орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийг шинэчлэн хавсралтаар батлалсугай.

2. Шинэчлэгдсэн дүрмийг Улсын бүртгэл бүртгүүлэн ажиллахыг Нийтлэг үйлчилгээний газар орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал (Д.Энхмаа)-д үүрэг болгосугай.

3. Сэврэй сумын Нийтлэг үйлчилгээний газар орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нийт хөрөнгийн хэмжээ нь 2014 онд 29,212,500 төгрөгийн хөрөнгөтэй үүсгэн байгуулагдаж 2025 оны жилийн эцсийн байдлаар 341,986,302.61 төгрөгөөр нэмэгдэж нийт хөрөнгийн дүн 371,198,802.61 төгрөг болсон тул хөрөнгийн өсөлтийг холбогдох санхүүгийн тайланд тусгаж, цаашид үр ашигтай ашиглах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Нийтлэг үйлчилгээний газар орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал (Д.Энхмаа), Няглтан бодогч (Б.Амарбаатар)-д нарт үүрэг болгосугай.

4. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шинэчлэн батлагдсан дүрэмд нийцүүлэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Засаг дарга (Б.Батсайхан)-д, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга (Ш.Одмаа)-д тус тус даалгасугай.

5. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 18 дугаар тогтоолын 2 дугаар заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Ч.ОГТБИШ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2026 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн
7/05 тоот тогтоолын хавсралт

СЭВРЭЙ СУМЫН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нийтлэг үндэслэл

Сэврэй сумын газар нутгийн 83 хувь нь улсын тусгай хамгаалалтанд, үлдсэн газар нутаг нь аймаг, сумын орон нутгийн хамгаалалтанд байдаг, аялал жуулчлал, мал аж ахуйг хөгжүүлэхээр сумын эрхэм зорилго тэргүүлэх чиглэлд тусгасан байдаг. Нийтлэг үйлчилгээний газар нь сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, иргэдийн аж амьдралыг дээшлүүлэхэд нэн тэргүүнд шаардлагатай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, иргэдэд зориулсан амралт, сувилал ажиллуулах тэдгээрийг удирдлага зохион байгуулалтаар хангах шаардлагын хүрээнд үүсгэн байгуулагдсан.

Нэг: Эрх зүйн зохицуулалт

1.1. Сэврэй сумын Нийтлэг үйлчилгээний газар орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь төрөөс баримтлах хууль тогтоомж, бодлого чиглэлийг баримтлан орон нутгийн хөрөнгө оруулалт, бусад төсөл хөтөлбөр, өөрийн үйл ажиллагааны орлогоор санхүүжин үйл ажиллагаагаа эрхэлнэ.

1.2. Нийтлэг үйлчилгээний газрыг үүсгэн байгуулагч нь Сэврэй сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйл, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэг тус тус үндэслэл болгоно.

1.3. Нийтлэг үйлчилгээний газрын удирдах дээд байгууллага нь Нийтлэг үйлчилгээний газрын Төлөөлөн удирдах зөвлөл байна Нийтлэг үйлчилгээний газрын Төлөөлөн удирдах зөвлөл нь 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөлд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга, сумын өмч хамгаалах зөвлөлийн дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, Засаг даргын Тамгын газрын Санхүү албаны дарга нар ажиллана. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь сумын Засаг дарга байна.

1.4. Сэврэй сумын Нийтлэг үйлчилгээний газар нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Монгол Улсын Компанийн тухай болон холбогдох хуулийн дагуу зохион байгуулагдсан, бие даасан тайлан тэнцэлтэй, банканд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээх хуулийн этгээд байна.

1.5. Сэврэй сумын Нийтлэг үйлчилгээний газар нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаандаа холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авсны дараа улсын бүртгэлд бүртгүүлж, тухайн үйл ажиллагааг эрхэлнэ.

Хоёр: Оноосон нэр, байршил

2.1 Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын оноосон нэр нь Сэврэй сумын "Нийтлэг үйлчилгээний газар" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, товчилсон нэр нь НҮГ- ОНӨААТҮГ байна.

2.2.Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын оршин байгаа газар, шуудангийн хаягийг түүний ерөнхий захиргаа буюу төвийн удирдлага байршиж байгаа газрын хаягаар тодорхойлно.

2.3. Нийтлэг үйлчилгээний газрын хаяг: Өмнөговь аймаг Сэврэй сум 1-р баг.

Гурав: Зорилго, үйл ажиллагааны чиглэл

3.1 Нийтлэг үйлчилгээний газар нь сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, иргэдийн аж амьдралыг дээшлүүлэхэд нэн тэргүүнд шаардлагатай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, иргэдэд зориулсан амралт, сувилал ажиллуулах зорилгоор үйл ажиллагаагаа дараах чиглэлээр явуулна.

3.1.1. Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх, хандивын сангийн менежмент хийх

3.1.2. Худалдан авах ажиллагаанд зөвлөх үйлчилгээг үзүүлэх, бэлтгэн нийлүүлэх

3.1.3. Иргэдийн боловсролыг дэмжих, сургалт, судалгааны үйл ажиллагаа явуулах

3.1.4. Нутгийн иргэдийн өв соёл, уламжлалыг хадгалах, өвлүүлэх, уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх

3.1.5. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, экологийн боловсролыг дээшлүүлэх

3.1.6. Хүмүүнлэгийн туслалцаа үзүүлэх

3.1.7. Зочид буудал ажиллуулах

3.1.8. Хоол, цайны газрын үйлчилгээ явуулах

3.1.9. Хээрийн болон сумын төвийн золбин нохой устгал хийх

3.1.10. Нийтийн тээвэр, зам засвар, тэмдэг тэмдэглэгээ хийх

3.1.11. Барилгын засвар хийх, малчдын хороо буудал, худаг ус засварлах

3.1.12. Иргэдэд мэдээлэл түгээх, сонин радио телевизийн үйл ажиллагаа явуулах

3.2. Хуульд заасан эрх бүхий байгууллагаас татан буулгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд үйл ажиллагаагаа хугацаагүй хэвийн явуулна.

3.3. НҮГ-ОНӨААТҮГ нь үйл ажиллагаандаа Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж, Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө тогтоол шийдвэрийг мөрдлөг болгон ажиллана.

3.4. НҮГ-ОНӨААТҮГ-нь орлогоо нэмэгдүүлэх зорилгоор зөвшөөрөгдсөн хэмжээнд нэмэлт төлбөртэй үйлчилгээг үзүүлж болно.

3.5. Хуульд нийцсэн бусад үйл ажиллагааг өргөн хүрээтэй зохион байгуулж болно.

Дөрөв: Эрх, үүрэг, хариуцлага

4.1. НҮГ-ОНӨААТҮГ нь дараах эрхтэй.

4.1.1. Сэврэй сумын Нийтлэг үйлчилгээний газар нь өөрийн албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тамга тэмдэг хэрэглэнэ.

4.1.2. Сэврэй сумын Нийтлэг үйлчилгээний газрын үндсэн ба туслах үйлдвэрлэл үйлчилгээний ажлыг хэвийн явуулах зорилгоор мэргэжил чадвар сайтай, дадлага туршлагатай менежментийн баг буюу хүмүүсийг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулах, тэдний ажиллах нөхцөл, цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтооно.

4.1.3. Шаардлагатай тоног төхөөрөмж, эд материалыг бүрдүүлэх, үл хөдлөх болон бусад эд хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааны зорилгод нийцүүлэн ашиглах, хамгаална.

4.1.4. Ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг Монгол Улсын болон гадаадын орны, Олон улсын байгууллага, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран ажиллана.

4.1.5. Энэ дүрмийн 3.1-д заасан үйл ажиллагаануудыг батлагдсан тарифаар үзүүлнэ.

4.2. НҮГ-ОНӨААТҮГ нь дараах үүрэгтэй.

4.2.1. Монгол Улсын хууль тогтоомж болон энэхүү дүрэмд нийцүүлэн үйл ажиллагаа явуулна.

4.2.2. Үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд шаардлагатай хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах, хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөж ажиллуулна.

4.2.3. Байгууллагын жилийн бизнес төлөвлөгөөг боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан батлуулж бүрэн хэрэгжүүлэх, цаашид маркетинг, менежментийг үр ашигтай, оновчтой бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

4.2.4. Төсвийг жилийн бизнес төлөвлөгөөнд тусгаж зориулалтын дагуу зарцуулна.

4.2.5. Санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэх, төсөв санхүү хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлнэ.

4.2.6. НҮГ-ОНӨААТҮГ-нь үйл ажиллагааны талаарх тайланг жилдээ нэгээс доошгүй удаа сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна.

4.2.7 НҮГ-ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирал, ажилтан, нягтлан бодогч нар нь гэрээнд заасан хугацаанд эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд хууль бус үйл ажиллагаанаас учирсан хохирлыг хариуцна.

Тав: Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх, үүрэг

5.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь дүрэмд заасны дагуу НҮГ-ОНӨААТҮГ-ын санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, бичиг баримттай танилцаж удирдан чиглүүлнэ.

5.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь НҮГ-ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулан гүйцэтгэх захирлын эрх үүрэг, хариуцлага, цалин, урамшууллыг тогтооно.

5.3. Төлөөлөн удирдах зөвлөл нь гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.

5.4. НҮГ-ОНӨААТҮГ-ын бүтэц орон тооны хязгаарыг Төлөөлөн удирдах зөвлөл батална.

5.5. Гүйцэтгэх захирал нь бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангалтгүй хэрэгжүүлсэн, өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хохирол учруулан, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зэрэг тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл ажлаас чөлөөлөх саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.

Зургаа: Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх, үүрэг

6.1. Гүйцэтгэх захирал нь НҮГ-ОНӨААТҮГ-ыг төлөөлнө.

6.2. НҮГ-ОНӨААТҮГ-ын нэрийн өмнөөс гэрээ хэлцэл байгуулна.

6.3. Ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах тэдгээрийн цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтооно.

6.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас тогтоосон эрх хэмжээний хүрээнд НҮГ-ОНӨААТҮГ-ын өмч хөрөнгийг захиран зарцуулна.

6.5. Гүйцэтгэх захирал нь НҮГ-ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүн, гэрээний биелэлтийг жилд нэгээс доошгүй удаа Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд тайлагнан дүгнүүлж байна.

6.6. Гүйцэтгэх захирал нь албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтээ Төлөөлөн удирдах зөвлөлд 30 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

Долоо: Санхүүгийн тайлан, хяналт шалгалт

7.1. НҮГ-ОНӨААТҮГ-нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хуулийн дагуу баталгаажуулан үүний үндсэн дээр татварын багц хуулийн заалтад нийцүүлэн тогтоосон хугацаанд нь тайлан мэдээг гаргаж тооцоог хийн дээд шатны байгууллагат тушаана.

7.2. НҮГ-ОНӨААТҮГ-ын санхүүгийн жил тухайн оны 1-р сарын 1ний өдрөөс эхэлж 12 дугаар сарын 31- ний өдрөөр дуусгавар болгоно.

7.3. Эд хөрөнгийн дотоод тооллогыг хугацаанд нь явуулж, жилийн эцсийн тайлан тэнцэлд тусгана.

7.4. Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдлыг Дарга, Нягтлан бодогч нар хариуцна.

Найм: Орлогын эх үүсвэр, хөрөнгө оруулалтын зарцуулалт

8.1. Орлогын бүрдүүлэлт

8.1.1. Орон нутгийн хөрөнгө оруулалт

8.1.2. Өмнөговь аймгийн Сэврэй сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хуваарилсан төсөв

8.1.3. Гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс өгсөн буцалтгүй тусламж, хандив

8.1.4. Гадаад улс олон улсын байгууллагаас Засгийн газрын шугамаар олгосон зээл

8.1.5. Үйл ажиллагааны өөрийн орлого

8.1.6. Бусад

8.2. НҮГ-ОНӨААТҮГ-ын хөрөнгийн зарцуулалт

8.2.1. НҮГ-ОНӨААТҮГ-нь сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, иргэдийн аж амьдралыг дээшлүүлэхэд чухал шаардлагатай төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, аялал

жуулчлалыг хөгжүүлэх, иргэдэд зориулсан амралт, сувилал ажиллуулах зэрэг дараах арга хэмжээг зохион байгуулахад хөрөнгийг зарцуулна.

8.2.1.1. Урт хугацаатай өндөр өгөөжтэй, эрсдэл багатай хөрөнгө оруулалтын хэрэгсэл

8.2.1.1.1. Арилжааны банкнуудад байршуулж хадгаламж гаргах

8.2.1.1.2. Хөнгөлөлттэй зээл гаргах

8.2.1.2. Сумын эдийн засгийн салбарыг хөгжүүлэх төслүүд

8.2.1.2.1. Дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх

8.2.1.2.2. Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх төслүүд

8.2.1.2.3. Хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх төслүүд

8.2.1.2.4. Сумын нийгмийн салбарыг хөгжүүлэх төслүүд

8.2.1.3. Боловсролын салбарыг хөгжүүлэх төслүүд

8.2.1.3.1. Нутгийн иргэдийн өв соёл, уламжлалыг хадгалан хамгаалах

8.2.1.3.2. Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх төслүүд

8.2.1.3.3. Орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх төслүүд

8.2.1.3.4. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлэх төслүүд

8.2.1.3.5. Хүмүүнлэгийн хөтөлбөрүүд

8.2.1.4. Хүрээлэн буй орчны тэнцвэрт байдлыг хадгалах, байгаль орчныг хамгаалах төслүүд

8.2.2. НҮГ-ОНӨААТҮГ-нь тухайн оны санхүүгийн тайлангийн татварын дараах ашгийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн сумын орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлнэ.

Ес: Өөрчлөн байгуулах, татан буулгах

9.1. НҮГ-ОНӨААТҮГ-нь дараах үндэслэлээр татан буугдана.

9.1.1. Төлбөрийн чадваргүй болж шүүхийн шийдвэрээр дампуурсан.

9.1.2. Үүсгэн байгуулагчийн шийдвэрээр цаашид үйл ажиллагаа явуулахгүй болсон.

9.1.3. Хуульд заасан эрх бүхий байгууллагаас татан буулгахаар шийдвэрлэсэн.

9.1.4. Хуульд заасан бусад үндэслэл.

---o0o---